

11

**БИДНИЙ АЧ ГУЧИЙН ЭДИЙН ЗАСГИЙН
ИРЭЭДҮЙН БАЙДАЛ**

Д.Хишгээ

Бид өнөөдөр эдийн засгийн гутрангуй үзлийн хурц ирмэг дээр амьдарч байнам. Амьдралын түвшинь өсөн дэвших хурд удааширснаар, XIX зууны бидэнд бэлэглэсэн эдийн засгийн гайхалтай өсөлт, дэвшлийн үе дуусч байна. Тухайлбал, Их Британы хувьд энэ үзэгдэл нь илт ажиглагдаж байгаагаас үзвэл, ойрын арван жилд эд баялаг нэмэгдэх бус харин багасах болоод байна.

Энэхүү яриа хөөрөөний үндэс нь бид эдийн засагт болж буй үйл явдлын талаар хэтэрхий гүнзгий төөрөлдсөнд оршиж байна. Архаг хуучтай, үе мөчний өвчин мэт шаналгадаг “өнгөрсөн үе” бус харин эдийн засгийн шинэ үе шат уруу шилжиж байгаа бэрхшээлээс үүдэлтэй, хэтэрхий хурдан өөрчлөлтийн буюу “өсөлт”-ийн өвчнөөс л бидэнд асуудал үүсч байгаа юм. Орчин үед “үйлдвэрлэлийн үр ашиг” түргэн хурдацтай өсөж байгаа бөгөөд энэ өсөлтөнд бид дасан зохицох, чөлөөлөгдөн гарсан ажлын байрыг нөхөж чадахгүйд хүрээд байна. Амьдралын түвшин төсөөлж байснаас илүү хурдан дээшилж, дэлхийн мөнгө, банк санхүүгийн систем ерөнхий тэнцвэрийг барьж байх хэмжээнд зээлийн хүүг барихыг хичээж байна.

Харин санхүүгийн энэхүү оролцооны алдагдалын үнэ цэнэ нь үндэсний нийт орлогын 7,5% -иас ихгүй харьцаатай байгаа юм. Бид нэг фунтээс 1 шиллинг 6 пенс алдсан нь нэг фунт олох боломжийн оронд зөвхөн 18,5 шиллингтэй болох бололцоотой, гэтэл энэ 18,5 шиллинг 5-6 жилийн өмнөх нэг фунттай тэнцэж байгаа юм. Их Британий аж үйлдвэрлэлийн бодит хэмжээ 1929 онд хамгийн өндөр байсан бөгөөд төлбөрийн балансын цэвэр үлдэгдэл, импортын төлбөр хийсний дараа гадаадад, шинэ хөрөнгө оруулалт хийхээр ашиглах боломжтой байсан нь бусад улс орнуудаас өндөр түвшинд байв. Тухайлбал АНУ-ын харгалзах цэвэр үлдэгдлээс 50% илүү байсныг бид мартжээ. Бид цалин хөлсийг хоёр дахин бууруулна гэж үзвэл үндэсний нийт өрийн 4/5-аас татгалзана гэсэн үг. Энэхүү бий болгосон баялгаа, орлого ба алт болгохын оронд жилийн 6 хувийн давхар хүүтэй хадгалж болно гэж үзье. Тэгвэл бид

өнөөдөр олонхи нь атаархан буй Францтай адилхан эдийн засагтай байхсан. Гэвч энэ алхмыг урьдчлан харж, хийж чадах болов уу ?

Бидний гаргасан ноцтой алдааны зэрэгцээ хэрэглээгээ өссөөр байтал нийт даяар ажилгүйдэл нэмэгдсэнээс дэлхий нийтийг хамарсан хямрал бий болсон нь бодит байдал дээр чухам юу болж байгаа, урт хугацааны хөгжлийн хандлага зөв эсэхийг харж чадаагүйгээс болжээ. Өнөөдрийн энэхүү өөдрөг бус үзлийн шалтгааныг хоёр үндсэн санаагаар илэрхийлэн тайлбарлаж болох юм. Үүнд:

- Бүх зүйл маш муу байгаа гэх хувьсгалчдын гутрангуй үзэл бөгөөд зөвхөн хүчирхийллийн аргаар өөрчлөлт хийнэ гэж тэд үзэж байна
- Нөгөө нь аз туршсан, осолтой туршилт хийж үзэхэд манай эдийн засаг болон нийгмийн баланс хэтэрхий хэврэг гэж үздэг аядуу үзэлтнүүд юм.

Энэ эссег бэлтгэхдээ, би өнөөгийн болон ойрын ирээдүйг шүүн хэлэлцэх зорилго агуулсангүй гагцхүү өнөөгийн энэ цаг үеэс эхлэн, ирээдүйн алсад ямар байхыг төсөөлөн харахыг оролдсон юм. Зуун жилийн дараа ахуй, амьдрал ямар түвшинд хүрэх, ер нь тэр ямар утга учиртай байх бол ? Бидний ач гуч нарт эдийн засгийн ямархуу боломж байна вэ? гэж эрэгцүүлэн бодлоо.

Эрт үеэс, өнөөг хүртэл хадгалагдаж ирсэн бичиг, баримтаас үзвэл МЭӨ - 2000 оноос XVIII зуун хүртэл, соёл иргэншлийн өлгий дэхь оршин суугчдын амьжиргааны дундаж түвшин төдийлэн өөрчлөгдөөгүй байгааг гэрчилдэг. Энэ хугацаанд нийгмийн дэвшил, хөгжил, уналт, хямрал зөндөө байсан нь тодорхой. Тухайлбал дайн, өлсгөлөн, өвчин тахалтай цаг үе тохиолдсон байдаг. Түүнчлэн “амар амгалан алтан зуун”-ы үе тохиосон ч бий. Гэхдээ ямар нэг эрс дэвшилтэт хувьсал, огцом өөрчлөлт гараагүй билээ. Зарим нэг үед өнгөрснөөс 50% , хамгийн их гэхэд 100% ийн ахиц гарсан гэж тооцсон ч 1700 он хүртэлх бараг дөрвөн мянган жилийн туршид онцгой өөрчлөлт, хувирал болоогүй юм.

Хөгжлийн энэхүү удаан өсөлт буюу хувирал дэвшилтгүй байсныг дараах хоёр шалтгаанаар тайлбарлаж болох юм : техникийн онцгой гэх, чухал ололт нээлт байсангүй, нөгөө нь капитал хуримтлуулах чадвар суугаагүй байсанд оршино.

Ялангуяа өгүүлэн буй түүхийн эхэн үеэс саяхныг хүртэл, гоц чухал техникийн нээлт байгаагүй нь үнэхээр сонирхолтой юм. Миний дурьдах гэж буй эрин үеийн шинэчлэл хүртэлх хүмүүсийн эзэмшиж хэрэглэж байсан бүх зүйл, түүхийн тэртээ цаг үеийнхтэй адилхан байгаа нь үнэхээр чухал ажиглалт юм. Хэл үүссэн, галыг нээсэн, одоо ч бидэнд байгаа гэрийн тэжээмэл амьтанг гаршуулснаас эхлэн арвай буудай, дарс, ..., тос, анжис, дугуй, усан тээрмийн сэлүүр, хөлгийн дарвуул, арьсан эдлэл, даавуу, нэхмэл, тоосго, вандуй, алт мөнгө, зэс, цайр, цагаан хар тугалга, төмөр зэргийг МЭӨ -1000 жилийн өмнө мөн л хэрэглэж байжээ. Харин төрийг удирдах урлаг, банкны үйл хэрэг, математик, астроном, шашин шүтлэг хэзээ анх үүссэн тухайг гэрчлэх баримт алга байна.

Хүн төрөлхтний иргэншлийн түүхийн эхэнд, ямар нэг цаг хугацаанд / мөстлөгийн өмнө эсвэл хойно үеийн тааламжтай нөхцөлд / хөгжил дэвшлийн дүр төрх, орчин үеийнхтэй адил байсан байж болох юм. Гэвч түүхийн урт хугацааг илтгэн харуулсан бичгийн дурсгал нь тийм явдал практикт ажиглагдаагүй болохыг харуулдаг.

Орчин үе : XVI зуунд капитал хуримтлагдахын хамт эхэлсэн гэж би бодож байна. Анхны хүчин зүйл бол үнийн өсөлт ба түүгээр өдөөгдсөн ашиг орлого юм . Эдгээр хүчин зүйлс испанчуудын Шинэ тивээс Хуучин тивд зөөвөрлөн авчирсан алт, мөнгөтэй холбоотой илрэн гарсан юм. Энэ үеэс эхлэн, зүүрмэглэн байсан давхар хүү сэрж өнөөг хүртэл үйлчлэн байгаа “үлгэрийн гайхамшигт” хүч чадлаа гаргаж эхэлсэн ажээ. Давхар хүүгийн үйлчлэлээр капиталын хуримталын хүч, хоёр зууны турш өсөхдөө бидний бүх л таамаглал төсөөллөөс давж гарсан билээ.

Үүнийг тайлбарлахын тулд, миний тооцоолон бодож гаргасан нэгэн баримтыг сонирхож болно. Их Британий гадаад хөрөнгө оруулалтын нийт өртөг өнөөдөр ойролцоогоор 4 млрд фунт. Энэ мөнгө жил бүр бидэнд 6,5% орлого оруулдаг. Үүний хагасыг гэртээ хэрэглээд үлдсэн хагас 3,5% -ийг давхар хүүтэйгээр гадаадад дахин зээлдэг бөгөөд барагцаалбал 250 жилийн турш энэ үйлдэл давтагдаж байна.

Их Британий гадаадад оруулсан энэхүү хөрөнгө оруулалт нь 1580 онд ахмад Дрейкийн испанчуудаас дээрэмдсэн алт, үнэт эдлэл байсан гэж тооцож болох юм. Энэ үед тэрээр Англид өөрийн “Алтан гөрөөс” хөлөг дүүрэн, үлэмж их баялагтай буцаж иржээ. Экспедицийг санхүүжүүлсэн консорциумд хатан хаан Елизеватын их хэмжээний хувьцаа байсан байна. Энэ хувьцаагаар хатан хаан Английн бүх гадаад өрийг дарж, төсвийн алдагдлыг бүрэн хааж дуусгаад, тэрч байтугай 40 мянган фунт үлджээ. Хатан хаан тэр мөнгөөр Левантийн компанид хөрөнгө оруулалт хийсэн нь асар их өсчээ. Левантийн компанийн өсгөсөн мөнгөөр Ост –Инд компанийг үндэслэсэн байна. Энэхүү аугаа алдартай, түүхт компанийн ашиг английн гадаад хөрөнгө оруулалтын цаашдын үндэс болсон байна. Английн төр өөр, өөр цаг үед гадаадад хөрөнгө оруулалт хийж ашигласан 3,5 % хүүтэй , 40 мянган фунтын бий болсон хуримтлал нь миний дээр дурьдсан өнөөдрийн Англи улсын гадаад хөрөнгө оруулалтын бодит тоо хэмжээ болох, дээр дурьдсан 4 млрд фунтыг бий болгосон юм. Ингэхээр Дрейкийн 1580 онд Англид авчирсан фунт тус бүр өнөөдөр 100 мянган фунт болон үржсэн байна. Давхар хүүгийн хүчин чадал энэ ажгуу .

XVI зуунаас анх эхэлсэн ба XVIII зуунаас чангаруулан дэлдсэн өсөлтийн хөгжмийн эгшгийн дор шинжлэх ухаан -техникийн нээлтийн аугаа эрин үед бид бахархалтай орж явчихлаа. Тэр хөгжил XIX зууны эхээр үндсэндээ бүрэлдэн, өнгө төрхөө олсон нь : нүүрс, уур, цахилгаан, ган, резин, хөвөн, химийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, тэдгээрийг их хэмжээгээр үйлдвэрлэх арга - механикжуулалт болон мэдээлэлийн технологи- радио холбоо, тогтмол хэвлэлийг үүсгэн бий болгож, Ньютон, Дарвин, Эйнштейн зэрэг суут хүмүүсийг төрүүлж, цаашид тоолохын аргагүй олон мянга эд юмсийг бүтээжээ.

Үүний үр дүн нь чухам юу болов? Хэдийгээр дэлхийн хүн ам асар түргэн өсөж, тэднийг байр байшин, машинаар хангах шаардлагатай болсон хэдий ч АНУ, Европт амьдралын түвшин ойролцоогоор дөрөв дахин өссөнийг би тооцоолсон юм. Капиталын нийт хэмжээ өмнөх үеийнхээс зүйрлэшгүй ихээр, тухайлбал 100 дахин өслөө. Иймд өнөө үед хүн амын огцом өсөлтөөс айх шаардлагагүй болов.

Хэрэв капитал жилийн 2% хүүтэйгээр нэмэгдвэл, 20 жилийн дараа тоног төхөөрөмжийн капиталын хэмжээ нийтдээ бараг хоёр дахин нэмэгдэж цаашилбал, 100 жилийн туршид 7,5 дахин өснө. Үүнийг материаллаг эд баялаг болох-орон сууц, тээврийн хэрэгслийн тоо хэмжээ өсөн нэмэгдэж байгаа баримтаар нотлож болно.

Түүнчлэн үйлдвэрлэл ба тээврийн салбар дахь техникийн шинэчлэлийн хурд сүүлийн арван жилд түүхэнд байгаагүй, төсөөлөхийн аргагүй ихэв. АНУ-д нэг ажилчний хөдөлмөрийн бүтээмж 1925 онд 1919 оныхоос даруй 40% нэмэгдэн өсжээ. Хэдийгээр Европт цаг хугацааны түр хүндрэл байгаа боловч техникийн ололт амжилт 1%-аас / давхар хүү / илүүтэйгээр өсч байна. Техникийн хөгжлийн энэхүү хувьсгал одоохондоо аж үйлдвэрийн салбарт байгаа боловч удалгүй хөдөө аж ахуйг хамрах нь лавтай. Уул уурхайн олзворлох, боловсруулах аж үйлдвэр, тээврийн салбарт гарсан хувьсгалт өөрчлөлт хүнсний аж үйлдвэрийн салбарыг үндсээр нь өөрчлөхөөр тулж ирсэн босгон дээр бид амьдарч байна. Ердөө хэдхэн жилийн дараа хөдөө аж ахуйн бүх салбарыг өөрчлөх ба олзворлох, боловсруулах аж үйлдвэрийн салбарт хүний хүчийг дөрөв дахин хэмнэх болно.

Одоо харин энэхүү өөрчлөлт, шинэчлэлтийн хурд өөрөө “өвчин” болж биднийг шаналгах боллоо. Хөгжил дэвшлийн тэргүүн эгнээнд явж байгаа биднийг нь бусад орнуудтай харьцуулбал тун ч тааруухан байдалд хүргэж байна. Зарим нэг уншигч мэдэхгүй, ойлгохгүй байж болох ч ойрын жилүүдэд – **технологоос үүдэлтэй ажилгүйдлийн** тухай олноор шаагих цаг удахгүй ирнэ. Учир нь бид хөдөлмөр хөнгөвчлөх технологи нээх тусам чөлөөлөгдөж байгаа ажиллах хүчийг шингээх чадварын хурд хөгжлийн өсөлтийг гүйцэхгүй болно.

Гэвч энэ нь уг өвчний цаг үедээ дасан зохицох зөвхөн нэгээхэн хэсэг. Ер нь удаан хугацааны туршид хүн төрөлхтөн өөрийн эдийн засгийн асуудлыг шийдсээр ирсэн юм. Хөгжингүй орнуудын амьдралын түвшин одоогийнхтой харьцуулбал 100 жилийн дараа 4-8 дахин өсөх байх гэж би төсөөлж байна. Өнөөдөр тодорхой болсон зүйлсийг тооцох юм бол үүнд гайхах зүйл огт байхгүй билээ. Түүгээр ч барахгүй хөгжлийн илүү хурдтай байх боломжтой гэж бодож байна.

II

Илүү тодорхой болгохын тулд 100 жилийн дараа бид эдийн засгийн байдлаа дунджаар найм дахин сайжруулна гэж үзье. Энэ үнэхээр биелэх боломжтой гэдэгт ямарч эргэлзээ байхгүй.

Түүнчлэн хүний хэрэгцээ ханашгүй гэдэг нь ч үнэн. Энэ хэрэгцээг хоёр хэсэгт хувааж болно. Бусад хүмүүст юу болж байгаагаас үл хамааран, бидэнд нэхэгдэж байдаг хэрэгцээг абсолют гэнэ. Нөгөө нь тухайн хэрэгцээ ханах үед бусдаас илүү гарч, өөрийн давуу талыг /харьцангуй гэж хэлж ч болох / мэдэрч эхэлдэг хэрэгцээ юм. Бидний бусдаас илүү гарах гэсэн хүслээр нөхцөлдөн бий болсон хоёрдох хэрэгцээ ханашгүй гэдэг нь : ерөнхий түвшин нь хэдийчинээ өндөр байна, төдийчинээ эрчимтэй / шуналтай / байдгаар тайлбарлагдана. Харин абсолют хэрэгцээний хувьд үүнээс өөр байдаг. Хэрэгцээгээ бүрэн ханах цэгтээ бид хүрч чадсан гэвэл, суларсан энергээ эдийн засгийн бус зорилгоор зарцуулахыг эрхэмлэж байдаг.

Энэхүү өөрийн дүгнэлтэнд би ийнхүү хүрсний дараа, та бүхнийг энэ талаар эрэгцүүлэн бодох тусам, улам их гайхшрух байх гэдэгт ихээхэн итгэлтэй байна.

Ямар нэг томоохон дайн, хүн амын гэнэтийн өсөлт тохиолдохгүй бол ойрын хугацаанд, дор хаяж 100 жилийн дотор “эдийн засгийн асуудлыг” шийднэ гэж би батлан өгүүлэе. Энэ юуг харуулж байна гээд ирээдүй тийш өнгийвөл, эдийн засгийн асуудал нь хүн төрөлхтний оршин тогтнохтой холбоотой асуудал байхаа болино гэсэн үг юм. Үүнийг сонсоод онцгой гайхмаар юм байхгүй мэт санагдаж болно. Гэвч хэдүүлээ ирээдүйн оронд өнгөрснийг харвал эдийн засгийн асуудал өнөөг хүртэл хамгийн гол тухайлбал : хүн төрөлхтний оршин тогтнож байх тэмцлийн үндсэн асуудал төдийгүй, бүх амьд биетний амьдралын энгийн хэлбэрийг хүртэл хамаарсан, амин чухал асуудал байсаар байв.

Тийм учраас эдийн засгийн зарим асуудлыг шийдсэн, бидний ухамсарлаагүй тэсэрсэн бүх л үйлдлүүд, гүн гүнзгий зөн совин бол байгалийн сонголт байж, түүгээр бид тодорхойлогдон оршиж байжээ. Хэрэв энэ эдийн засгийн асуудлыг шийдчихвэл хүн төрөлхтөн өөрийн “уламжлалт “зорилгоос салан ангижрах болно.

Ингэснээр сайн юм болох уу. Хэрэв бид хүн төрөлхтний амьдралын үнэт зүйлд итгэдэг бол дээр тодорхойлсон ирээдүй маань хамгийн багаар бодоход түүнийг сайжруулах боломж юм. Гэвч би жирийн хүмүүс олон үеийн турш бий болсон, эдийн засагт уягдсан зан заншил, зөн совингоосоо хэдэн аравхан жилийн дотор татгалзаж чадна гэдгээс л ихээхэн “эмээж” байна.

Үүнийг орчин цагийн хэлээр буулгавал, бүх нийтийн “сэтгэл зүйн хямрал” бөгөөд тэр биднийг ийнхүү хүлээж байна уу? Сэтгэл зүйн хямралын тийм өвчин, өнөөдөр Англи, АНУ-ын чинээлэг давхаргын эмэгтэйчүүдийн дунд, хэт баяжиж өдөр тутмын, жирийн ажил үйл эрхлэхээ больсноос үүдэн илрэх болов. Эдийн засгийн хувьд угаах цэвэрлэх, оёх, хоол унд бэлтгэх шаардлагагүй болсон тэд, цаг нөхцөөх өөр зүйл олж чадахгүй байна.

Харин хэрчим талхны төлөө өдөр бүр хөлсөө урсгагч хар ажилчид амралт, чөлөөт цагийг юу юунаас илүү хүсэж байдаг боловч түүнийг одоохондоо эдэлж чадаагүй байна. Нэгэн хөгшин зарцын өөртөө зохиож, олонд түгж алдаршсан дуунд өгүүлэхдээ:

Найдвартай, мөнхийн чөлөө цагаа би нэгэнт олж авлаа

Найз нар минь, намайг ямагт өрөвдөн уйлахаа зогс доо.

Түүнд диваажин ийнхүү төсөөлөгдөж байгаа ажээ. Бусдын нэгэн адил түүнд, чөлөөт цаг зав хангалтгүй болохоор хөгжим сонсох хичнээн тааламжтайг ч мэдэхгүй болохоо дараах хоёр мөрөнд ийн дуулжээ:

Зөндөө олуулаа нийлэн, мөргөл, залбирлыг дуулсаар боловч

Зөвхөн би ганцаар тунан, дуулж чадахгүй агаад хүсэхгүй нээ хэмээжээ. Үнэхээр тэрхүү тэвчишгүй, хүнд хөдөлмөрийн дунд байгаа тэдний дотор яаж дуулахыг мэддэг, тэгээд ч дуулдаг нь хэд билээ.

Хүн анх төрсөн цагаас эхлэн, бүхэнд нийтлэг байдаг бодит асуудалтай тулгардаг нь: эдийн засгийн амин чухал хэрэгцээ дээр өөрийн эрх чөлөөг яаж ашиглах, шинжлэх ухааны ололт, өөрийн амьдралыг зөв ухаалгаар залснаар - давхар хүүгээр бий болсон чөлөөт цагийг яаж ашиглах вэ, өөртэйгөө хэрхэн зохицон амьдрах вэ гэсэн асуудлууд байдаг.

Бусдаас илүү энерги- эрчтэй, тодорхой зорилго тавьсан ажилч хэсэг нь эдийн засгийн хүч нөлөөнд орж биднийг араасаа дагуулах нь ч бий.

Одоохондоо ирээдүйн эрин зууны баяр хөөр, хайр цэнгэлийн тухай сэтгэл зовнин бодохгүй нэг ч улс орон, үндэстэн байхгүй бизээ. Бид тэмцэлдэх, тэмүүлэхэд хэтэрхий удаан суралцаад, харин тэмцлийн үр шимийг бахдан, цэнгэн хүртэж чаддаггүй юм уу даа. Онцгой авьяас чадваргүй жирийн хүний тухайд уламжлалт хуучин нийгэмд энэрэх, эерэг сэтгэл буюу зан заншил цэцэглэх хөрс шороо байхгүй бол өөртөө зориулан, ямар нэг цаг өнгөрөөх зөв зүйл олох нь маш түвэгтэй хэрэг юм. Дэлхий ертөнцийн хаа нэгтээ баян чинээлэг хэсгийг түлхэн унагаах гэсэн бодол санаа байдгийг шүүн тунгаавал бидний энэ ирээдүй маш гунигтай санагддаг. Учир нь тэд бол хүмүүсийн хүссэн ажил төрлийг бий болгож, газар нутгийг нээн илрүүлж, хот-лагерь байгуулж, нийгмийг чирэгч тэргүүн эгнээг бүрдүүлсэн, манлайлагч нар юм. Тиймээс ямар нэг албан тушаал, үүрэг хариуцлагатай холбоогүйгээр орлого олдог хүмүүс миний бодлоор, бидний өмнөө тавьсан зорилгыг шийдвэрлэж чадахгүй байх.

Хэдий их биш боловч, хуримтлуулсан туршлагын үндсэн дээр байгаль эхийн өгсөн буянаа, бид өнөөгийн баячуудаас илүү ухаалаг ашиглаж, өөрийн амьдралыг тэдэн шиг биш өөрөөрөө төлөвлөж / төсөөлж / чадна гэдэгт би итгэлтэй байна. Цагийн жамаар давалгаалан ирж, өнгөрсөн олон зууны турш анхдагч болох Адам бидний дотоод сэтгэлд, хүн бүр бага зэрэг ажиллаж байж, сая сэтгэл ханаж байна гэдэг үзлийг бидэнд гүн гүнзгий суулгасан юм. Үүний зэрэгцээ тосыг талханд аль болох нимгэн түрхдэгтэй адил, бүгдээрээ хийх зайлшгүй ажил маань олон хүнд хуваагдаж байвал зохистой. Асуудлыг боломжтой удаан хугацаагаар тухайлбал 3 ээлжтэй ажлын цагийн хувиараар эсвэл 15 цагтай ажлын 7 хоног гэж хойшлуулж чадвал хөгшин Адамын хувьд

өдөрт 3 цаг ажиллах нь хангалттай тул тэр бидэнд сэтгэл хангалуун хандаж байх болно.

Ирээдүйд амьдралын бусад хүрээнд ч өөрчлөлт биднийг хүлээж байна. Нийгмийн үндсэн зорилгыг баялаг хуримтлуулах гэж үзэхээ болих цагт хүмүүсийн зан, ёс суртахууны хэм, хэмжээнд өөрчлөлт гарах болно. Хоёр зууны туршид өдөр бүрийн ёс суртахууны хуурамч хэм хэмжээгээр хүний мөн чанарыг хордуулан зовоож асан зарчмаас салж, хүн төрөлхтөн сайн үйлийн өндөр түвшинэ зэрэг дэвд дээшлэн шилжих болно. Бид эд хөрөнгөнд шунан, баялаг хураахын жинхэнэ үнэ цэнэ, хэмжээ хязгаарыг ухаалгаар тогтоох боломжтой болно. Мөнгөтэй болох шунал, мөнгийг амьдралын хангамж, үнэт зүйл бүтээх хэрэгсэл болгох зэрэг ойлголтуудыг ялгаж үзэх нь зүйтэй, ер нь шунал бол ямар нэг байдлаар бараг гэмт хэрэг бөгөөд хагас мэдрэлтэй болох зэрэг ичгэвтэр өвчний хэлбэрээр илэрч, улмаар сэтгэл зүйн хямралыг эмчлэх мэргэжилтнүүдэд хандахад хүргэдэг.

Өөрийхөө сэтгэл ханамжийг орлох өөр зүйл олглоо, материаллаг баялгаа нэмэгдүүлэхээр ухаангүй зүтгэсээр мөн чанар, ухамсараа алдаж зөвхөн түүний төлөө зорилго, үйл ажлаа чиглүүлдэг олон хүмүүс бас байна. Харин тэдгээрийн цаана нь үлдэгсэдийн “зорилго тэмүүлэл” –ийг нь байгалиас янз бүрээр зэрэглэн тогтоосон байдаг учраас дээрх хүмүүсийн энэ үйл ажиллагааг дэмжих, сайшаах үүрэг хүлээдэггүй байна. Угаасаа энэхүү зорилго тэмүүлэл гэдэг бол бидний үйл ажиллагааны саланги үр дүнг нэгтгэн эмхэтгэх гэж зорьж байгааг илэрхийлдэг бөгөөд тэрхүү үйл ажиллагаа өөрөө буюу түүний нөлөө биднийг хүрээлэн байгаа ертөнцтэй шууд холбогдож байдаг.

Зорилго тэмүүлэлтэй хүн нь өөрийнхөө өнөөгийн ашгийг дараа болгон тавих бөгөөд уг үйл хэргийн хуурамч, үр ашгийг нь хэзээ ч олж авч чадахгүй гэдгээ мэдэх боловч, тийм зүйлийн төлөө ямагт зүтгэж байдаг. Тухайлбал тэр өөрийн мууранд биш харин зулзаганд нь хайртай байх жишээтэй агаад, үнэндээ зулзаганд нь ч биш, түүний дараагийн үр удамд гэх мэтээр цаашлан муурын төрөл дуустал хайрлах хэрэгтэй болдог ажээ. Хэрэв маргаашийнх биш л бол өнөөдрийн жимсний чанамал түүнд хэрэггүй тул, хоол биш байх жишээтэй. Өөрийн энэ жимсний чанамалыг ирээдүйд хэрэглэхээр хадгалснаар хүнс хадгалах “төгсгөлгүй мөнх” өөрийн үйлийг үргэлжлүүлсээр л байх болно.

“ Сильвия Бруно хоёр “ өгүүлэгийн Профессорын дурсамжаас:

- Ноёнтоон, Би өчүүхэн оёдолчин хүн шүүдээ, та надад ялихгүй хэдэн зоосны тооцоотой юм байна гэх дуу хаалганы цаанаас сонсогдох аж.
- За, уучлаарай хүүдүүдээ, би энэ асуудлыг хурдхан шийдчихье гээд яг энэ үед үүдний өрөөнд орж буй оёдолчинд хандан
- –Одоохон гээд, би танд энэ жил хэдий хэмжээний өртэй билээ гэхэд
- Тооцооноос харвал, энэ жил та хоёр дахин их өртэй болсон байна гэж оёдолчин уцаарлангуй хариулаад, би энэ мөнгөө яаралтай авмаар байна. Танд нийтдээ хоёр мянган фунт өр байна гэвэл,

- **Өө, энэ яахав, юу ч биш гэж профессор хайхрамжгүй дуу алдаад, мөнгийг нь одоохон хармаанаас гаргаад өгөх гэж буй мэт тэмтэрснээ**
- **Дахин нэг жил хүлээгээд дөрвөн мянга болгож авья гэж хүсэж байна уу. Та тэгвэл бүр их мөнгөтэй болж, баяжих нь байна шүү дээ . Та хүсэх юм бол түүгээр эрхэм дээд гүн ч болж чадахсан гэвэл**
- **Гүн болох гэж бодохгүй байна, харин бөөн мөнгөтэй болох нь үнэн бол ч харин, гэж оёдолчин бодлогошронгүй өгүүлээд**
- **Би яахав хүлээж болох л юм гэв.**
- **Тэгэлгүй яахав гэж профессор дэмжин өгүүлээд , би таныг ийм ухаалаг хүн гэж мэдээд байсан юм. За одоо тэгвэл баяртай гэе гээд түүнийг үдэв.**
- **Та үнэхээр түүнд дөрвөн мянгийг төлөх юм уу гэж зээлдэгчийг хаалга хаасны хойно Сильвия асуувал,**
- **Яалаа гэж дээ, хонгор минь хэмээн профессор гудиггүй хариулаад, тэр үхэн үхтлээ өөрийн өрийг хоёр дахин өсгөхийг хүссээр байх болно. Зээлсэн мөнгөө жил бүр хүлээж байхдаа, хоёр дахин өсгөнө гэдэг чинь үнэхээр цэцэн ухаан биздээ гэлээ.**

Бидний шүтдэг үхэлгүй мөнхийг амлагч шашны үндэс хийгээд, оршин тогтнох нөхцөл бий болгоход бүхнээс илүүг хийсэн, давхар хүүгийн зарчмыг боловсруулахад хамгийн жинтэй хувь нэмэр оруулж, хүн төрөлхтний бүх л институтаас хамгийн их “ зорилго тэмүүлэлтэй “ байдгаараа онцгой ялгагдсан ард түмэн байгаа нь тохиолдлын санамсаргүй хэрэг бус аа.

Иймээс удамт сайн хүмүүс, хоёрдмол зарчимгүй шашин, зарим нэг илт тодорхой зүйлийг эргэн харж болох мэт надад санагдаж байдаг юм. Тухайлбал: мөнгийг өсгөх гэсэн хомхой шунал нь нүгэл, бүгдээрээ маргаашийн сайн үйлд зорин цэцэн мэргэний замаар замнах үед мөнгөнд дуртай болох нь хорт муу үйл болно. Бид дахиад л арга хэрэгслээс илүү, ашигтай сайн үйлийг дээдлэн зорьж байна. Энгийн эд зүйлд, тухайлбал ямарч асаргаагүй , орооцолдохгүй аяндаа ургаж байдаг сараана цэцгэнд хүртэл баярлаж чаддаг, өдөр бүр яаж амьдрахыг бидэнд зааж, сайн үйлийг ямагт оюун ухаанаараа удирдаж байдаг сайн хүмүүсийг гүн талархалтайгаар үнэлэх ёстой билээ.

Энэ бүхний ирэх цаг нь одоохондоо болоогүй учраас болгоомжтой байхад илүүдэхгүй. Ойрын 100 жилийн турш өөртөө болон бусдад- хар бол ашигтай харин цагаан бол ашиггүй байх учраас, цагаан бол хар, хар бол цагаан гэж итгүүлсээр байх болно. Ховдог шунахай сэтгэл, эдийн шунал, мөнгө хүүлэх сонирхол зэрэг нь нилээд хугацааны турш бидний “бурхан” хэвээр байх болно. Тэгэхдээ зөвхөн тэд л биднийг эдийн засгийн “зайлшгүй хэрэгцээ”-нд баригдсан энэ харанхуй хонгилоос өдрийн гэгээнд гаргах чадвартай юм шүү.

Хүн төрөлхтний оршин тогтнох материаллаг нөхцөлд тун удахгүй түүхэн өөрчлөлт гарахыг би ийм маягаар төсөөлөн хүлээж байна. Энэ өөрчлөлт мэдээж алгуур аажим хийгдэх байх. Гэвч үнэндээ, энэ өөрчлөлт хэдийнээ эхэлчихсэн байна. Эдийн засгийн асуудал практикт нь шаардлагагүй болох бүлэг, хэсэг, давхарга нийгэмд цаашид улам олноор үүсэх болно. Бид энэ өөрчлөлтийг бүрэн хэмжээгээр нь, ойр дотныхонд хандах бидний үүргийг илэрхийлэгч философи өргөн цар хүрээгээрээ өөрчлөгдөх тэр үед л мэдрэх болно. Хэрэв зээ өөрөө өөртөө тавьсан, бидний эдийн засгийн зорилго тэмүүлэл утгаа алдах болно гэвэл, энэ нь бусдад хандах харьцаа утгагүй болно гэсэн үг биш шүү.

Биднийг эдийн засгийн таатай байдалд хүргэх хурд дөрвөн хүчин зүйлээс хамаарах юм. Үүнд :

1. Бидний хүн амын тоог хянан барих чадвар,
2. Нийгмийн институтын дайн болон иргэний үймээн самууныг арилгаж байх шийдвэрлэг алхам,
3. Хэрэглэгээ-үйлдвэрлэлийн хоорондох ялгаагаар нөхцөлдсөн капиталын хуримтлалын хурд зэрэг шинжлэх ухааны асуудлыг шийдвэрлэхэд бүхнийг зарцуулж чадах бэлэн байдал
4. Дөрөвдөх хүчин зүйл нь эхний гурван зорилтыг шийдвэрлэж чадвал өөрийгөө хянах боломжтой болоход оршино.

Зорилго тэмүүлэлийг хөхүүлэн дэмжих , амьдрах урлагийг бидний нийтлэг хувь заяаг хүлээн авахад бэлтгэн, алгуур туршихыг зэрэгцүүлэн хийх нь тийм ч их хор хохирол учруулахгүй гэж бодож байна.

Хамгийн гол нь: Эдийн засгийн асуудлын чухал зайлшгүй гэдгийг хэтрүүлэн үнэлснээр, эдийн засгийн зайлшгүй хэрэгцээгээр шалтаглан, бусад илүү чухал юмсыг сүйтгэж хаяж болохгүйг анхаарах хэрэгтэй билээ. Энэ нь манай мэргэжилтнүүдийн уяа хазаар байж, яг л шүдний эмч шиг ажиллах ёстой гэдгийг харуулж байна. Хэрвээ эдийн засагчид өөрийн тухай бодохдоо – ажилдаа үнэнч мастер болсон, даруухан шүдний эмч шигээр боддог бол маш сайн байхсан билээ.

Бидний алдах эрхгүй боломж

/Орчуулагчдын зүүлт/

Кейнсийн “Бидний үр хүүхдийн эдийн засгийн боломж “өгүүллэгийг анх удаа монгол хэл дээр орчуулан нийтэлж байна. Өгүүллэгт дэвшүүлсэн санаа эдийн засагчдийг дахин дахин түүнийг эргэн харахад хүргэж байдаг нь: саяхан уг өгүүллэг нийтлэгдсэний 75 жилийн ойг тохиолдуулан “Кейнсийг дахин дурсахуй “¹ хэмээх нэртэй томоохон эмхтгэлийг 17 эрдэмтэд, түүний дотор 5 нобелийн шагналтнууд хамтран бичиж нийтлүүлснээс тодорхой байна.

Дээрх өгүүллэгийг Кейнс нийгмийн түвшин, тайван үед бичээгүй болох нь тодорхой. Өгүүллэгт дэвшүүлсэн санаагаараа анх 1928 онд

Кембриж, Винчестрийн их сургуулийн оюутнуудад лекц уншиж байв. Дараа нь Их хямралын байдлыг харьцуулсан нэмэлт оруулаад 1930 онд Мадридад бүрэн лекц хэлбэрээр бас уншжээ. Эцсийн хувилбарыг “Итгэл үнэмшлийн туршлага “ /1931/ нэртэйгээр номондоо хэвлүүлсэн байдаг.

Өгүүлэг яагаад алдаршив. 1923 онд “Мөнгөний реформын тухай “ өгүүлэг нийтлэгдэн гарахад тэрээр ийн дурссан байдаг : эдийн засгийн нам тайван урт хугацааны турш эдийн засагч бид бүгд үхсэн мэт байдаг гэжээ. Тиймээс Кейнсийг зөвхөн одоо байгаа цаг хугацааны асуудлыг шийдэж байдаг бөгөөд урт удаан хугацаанд үргэлжлэх асуудлын талаар ойлгож байгаагүй тул эдийн засгийн өсөлтийн сэдвээр харьцангуй их судалж, бүтээл туурвидаг гэж үзэж байжээ. Хэдий тийм боловч уншигч танаа толилуулж байгаа энэ өгүүллэгээрээ Кейнс тэр үеийн үзэл санаанаас давсан, тухайлбал эдийн засгийн өсөлтийн хүчин зүйлүүд / техникийн дэвшил, капитал хуримтлал /, хөрөнгө эд баялгийн түвшин 100 жилийн дараа ямар байхыг / 4 дахин тэрч байтугай 8 дахин өсөхийг / урьдчлан харж чадсан байдаг. Эцэст нь Кейнс 100 жилийн дараа “нийгмийн үнэт зүйл” ямар байх тухай төсөөлөн хэлж чадсан билээ.

Хүссэн хүн бүр амьдарч чадахааргүй тийм төгс нийгмийг, тусгай оюунлаг хүрээлэлийн нөлөөн дор байгуулж болох тухай Кейнсийн үзэл санаа байгаа нь тодорхой байна. Дээрх эмхтгэлийг зохиогчид “Кейнс эдийн засгийн ирээдүйн өсөлтийн хурд, амьдралын түвшний дээшлэлтийг ирээдүйд хөдөлмөрийн бүтээмж хэрхэн өсөх, чөлөөт цаг , хэрэглээ болон хадгаламж ямар хандлагатай байхыг өчүүхэн ч алдаагүйгээр яаж оюун ухаандаа гүнзгий ойлгон мэдэрч, хэлж чадав”^{3 1} гэдгийг тайлбарлахыг оролдсон юм .

Гэхдээ Кейнс хаана алдав ? Амьдралын түвшин өссөн хэдий боловч, бид урьдын адил хэрчим талхны төлөө хөлсөө гоожуулсан хэвээр л байна? АНУ-д , Японд ч тэр өнөөдөр Кейнсийн тэр үеийн өгүүлсэн шиг хөдөлмөрийн цаг үргэлжилсээр л , Европт арай бага болсон мэт боловч өдөрт гурван цаг болоогүй л байна. Хүмүүсийн ажлаас авч байгаа сэтгэл ханамжийг Кейнс гүйцэд үнэлээгүй ч байж болох юм. Энэ сэтгэл ханамж нь бүтээл, бүтээмжээс авч байгаа таашаал болон, ажлын хамт олонтой харилцах энгийн таашаал ч байж болох юм.

Нөгөө нэг алдаа нь орлогын тэгш бус хуваарилалтын тухайд гэж үзэж болох юм. Хөгжиж байгаа улс орнууд улам баян болж байгаа АНУ-ын араас даган баримжаа авч, гүйцэхийг чармайн шаргуу хөдөлмөрлөсөөр л байна. Кейнсийн хувьд чухал үүрэг гүйцэтгэхгүй гэж үзэж байсан “тансаг хэрэгцээ” нь харьцангуй хэрэглэгээнд ихээр

³ Rothbard M. Keynes, the Man. 1992

нөлөөлөх болсон бөгөөд абсолют хэрэгцээ ханах цэг ч тодорхой бус байна.

Энэхүү итгэлтэй хэлж байгаа үзэл бодлын эх үүсвэрийг Кейнсийн өгүүллэг гарахаас өмнө нийтлэгдсэн Ф.Рамсеягийн “Хуримтлалын математик онол” –оос харж болох юм. Ф. Рамсея өгүүлэлдээ макро эдийн засгийн чухал асуудлууд болох үндэстнүүд өөрийн орлогын ямар хэсгийг хэрэглэж, ямар хэсгийг хадгалах хэрэгтэй вэ, капиталыг хуримтлуулж ханах хэмжээ хязгаар ямар байвал зохистой вэ? ⁴ гэсэн асуултанд хариу өгөхийг оролджээ.

Ф.Рамсея сэтгэл ханамж нь эдийн засгийн өсөлтийн үр дүн учраас төгсгөлгүй өсөж болохгүй. Учир нь эдийн засгийн хүчин зүйлүүд өөрөө аяндаа бидэнд ханамжийн эцсийн түвшний зөвхөн зарим хэсгийг л өгч чадна гэж үзэж байжээ. Капиталын түвшин бүрт “ханамжийн” харгалзах түвшинг харгалзуулж тавьж болох бөгөөд капитал хуримтлагдахын хирээр мөнөөх түвшин Рамсеягийн “эд баялагт ханах” цэг гэж нэрлэсэн хязгаарт ойртоно. Кейнс Рамсеягийн үзэл санааг хуваалцаж, “сайн сайхан байдал” гэсэн нэр томъёог зээлдэн авч, ажил хийх нь өөрийгөө тайвшруулах онцгой үзэгдэл болсон нийгмийн тийм гайхамшигтай байдлын тухай тодорхойлж байв. Тэрээр “абсолют” хэрэгцээний тухай ойлголтыг Рамсеягаас шууд хуулбарлан авч “харьцангуй” хэрэгцээний эсрэг тавьсан юм. Энэ ангилал нь эргэлзээтэй асуудал болсон нь юуны өмнө, төрөл бүрийн хэрэгцээ нь яагаад тодорхой баялагт биелэлээ олж байгаа нь ойлгомжгүй байна.

Төрөл бүрийн хэрэгцээний хоорондын харьцааны тухай Кейнс бидэнд юу ч дурсаагүй юм. Үүний зэрэгцээ харьцангуй хэрэгцээний эзлэх хувь хэмжээ сүүлийн 80 жилд ихээхэн өссөн гэх үндэслэл байгаа юм.

Стиглиц үзэхдээ, хэрэв хувь хүний хэрэгцээ /ашигт байдал / зөвхөн бусдын хэрэгцээнээс хамаардаг бол цалин хөлсний нэмэгдэл нь аль нэг агентийн чөлөөт цагийн зохистой байдалд ямар ч нөлөө үзүүлдэггүй байна ⁵ гэжээ. Стиглицийн тайлбарт бүр илүү сонирхолтой үр дүн байгаа нь “оюуны эрхэмлэл”-ийн дотоод мөн чанарыг тооцоон оруулсанд байгаа юм.

Тухайлбал хоёр хүн нэг өрөөнд хамт ажилладаг албан хаагчид бөгөөд нэг нь гэртээ хөгжим байнга сонсдог ажээ. Тэдний нэг нь илүү ажилсаг, нөгөө хөгжим сонсдог нь арай бага эрчимтэй ажилладаг байв. Илүү сайн ажилладаг нь ажлаа шуурхай эхлэн, цаашид уйтгартай хэвийн үргэжлүүлдэг байтал, хөгжим сайн сонсдог нь хүний ярианаас их таашаал авч, хариуцсан ажил нь сайн бүтдэг байна. Ингээд хэдэн жилийн дараа бид нэг нь албаны муйхар

⁴ Ramsey F.P. A Mathematical Theory of Saving The Economic Journal.1928

⁵ Stiglitz J.Toward a General Theory of Consumerism

ажилтан, нөгөө нь эвсэгхэн харилцаатай хоёр өөр төрлийн хүн бий болсныг гэнэт гайхан харах болно.

Хэдийгээр өгүүллэгийн социологийн хэсэгт биелэгдэшгүй таамаглалууд байгаа хэдий ч эдийн засгийн талаар урьдчилан харсан нь бараг бүхэлдээ биелжээ. Ирээдүйг харагч –Кейнсийн нийгэм-философийн үзэл санаа цаашид судлаачдад сонирхолтой хэвээр байх нь дамжиггүй. Кейнсийн эдийн засгийн өсөлтийн асуудлын тухай дээрх дүгнэлт нь формаль арга ашиглаагүй шийдсэн бөгөөд зөн билгийн оновчтой жишээ хэвээр үлдсэн ажээ.

Их хямралаас хойш эдийн засгийн хөгжлийн хамгийн хүнд үе, өнөөдөр шилжилтийн эдийн засагт амьдрах бидний хүрээнд ч тулгарч, 80 жилийн өмнөх шиг капитализм дотроо зөрчилтэй, тогтворгүй байх , хямралаар энэ систем төгсгөл болох тухай эрэгцүүлэн бодоход хүргэж байна. Харин Кейнсийн дээрх өгүүллэг чухамхүү энэ хямрал л 100 жилийн дараа хүн төрөлхтний эд баялаг ямар байх , бидний үр хүүхдэд эдийн засгийн ямар боломж бий болох зэрэг урт хугацааны чиг хандлагыг дахин бодох тухай сануулж байгаагаараа ач холбогдолтой юм.